



СИЛИКАТ ХК

Дархан хот, Үйлдвэрийн Дүүрэг,
Силикат компанийн байр.

ХӨНГӨН БЕТОН ШОХОЙН ҮЙЛДВЭР

№ _____

20... он ... -р сарын ...

“СИЛИКАТ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 03

Дархан Уул аймаг

Зах зээлд санал болгох үнэ тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйл, хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Нэмж гаргаж буй хувьцааг зах зээлд санал болгох доод үнийг 225 төгрөгөөр тогтоосугай.



ХУРЛЫН ДАРГА: Ж.ГАНБОЛД

Утас/ Факс: 976 1372024755, И-мэйл: info@silikat.mn



СИЛИКАТ ХК

Дархан хот, Үйлдвэрийн Дүүрэг,
Силикат компанийн байр.

ХӨНГӨН БЕТОН ШОХОЙН ҮЙЛДВЭР

№ _____

20... он ... -р сарын ...

“СИЛИКАТ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 04

Дархан Уул аймаг

Дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17, 63 дугаар зүйл, хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэчилсэн найруулга бүхий дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэчилсэн найруулга бүхий дүрмийг хуульд заасан хугацаанд багтаан улсын бүртгэлд бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал /Ц.Содбилэгт/- т үүрэг болгосугай.
3. Шинэчилсэн найруулга бүхий дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс 2005 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Хувь нийлүүлэгчдийн хурлаар батлагдсан компанийн дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.
Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудал нь хувь нийлүүлэгчдийн 2008 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурлын хэлэлцэх асуудалд орж шийдвэрлэгдэж байсан болно.

ХУРЛЫН ДАРГА: Ж.ГАНБОЛД

Утас/ Факс: 976 1372024755, И-мэйл: info@silikat.mn

“СИЛИКАТ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 02

Дархан Уул аймаг

Нэмэлт хувьцаа гаргах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 34, 39, 63-р зүйл, Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 (арван зургаан сая хоёр зуун хорин хоёр гурван зуу) ширхэг хувьцааг зах зээлд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлсүгэй.
2. Нэмж гаргаж буй хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй, олон нийтэд адил эрхтэйгээр зах зээлд санал болгосугай.
3. Нэмж хувьцаа гаргасны дараа компани нь нийт 46 334 602 (дөчин зургаан сая гурван зуун гучин дөрөв зургаан зуун хоёр) ширхэг хувьцаатай байхаар тогтож компанийн дүрмийн заалтад өөрчлөлт оруулсугай.
4. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, зуучлагчтай гэрээ байгуулан олон нийтэд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлж, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахыг гүйцэтгэх захирал Ц.Содбилэгт үүрэг болгосугай.

Нэмж хувьцаа гаргах тухай асуудал нь хувь нийлүүлэгчдийн 2008 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурал, 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэгдэн тогтоол шийдвэрүүд гарч байсан болно.

ХУРЛЫН ДАРГА:  Ж.ГАНБОЛД





ХӨНГӨН БЕТОН ШОХОЙН ҮЙЛДВЭР

СИЛИКАТ ХК

Дархан хот, Үйлдвэрийн Дүүрэг,
Силикат компанийн байр.

№ _____

20... он ... -р сарын ...

“СИЛИКАТ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 01

Дархан Уул аймаг

Хувьцаа хуваах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 52, 63-р зүйл, компанийн дүрмийн 6-р зүйл, “Сүлд Аудит” ХХК-ийн аудиталсан 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан эзэмшигчийн өмчийн дүн болон Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани нь өөрийн хувьцааны зах зээл дэх эргэлтийг идэвхижүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зорилгоор нэгж хувьцааг 177 ширхэгт хуваасугай.
2. Хувьцаа хуваагдсаны дараа компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 (гучин сая нэг зуун арван хоёр гурван зуун хоёр) ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. Хувьцаа хуваагдан компанийн нийт хувьцаанд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэн, бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал Ц.Содбилэгт үүрэг болгосугай.

Хувьцаа хуваах тухай асуудал нь хувь нийлүүлэгчдийн 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурал, 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэгдэн холбогдох шийдвэрүүд гарч байсан болно.



ХУРЛЫН ДАРГА: Ж.ГАНБОЛД